

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ - ажил олгогч болон тантай буюу ажилчин хоёрын хоорондох баримт бичиг бөгөөд үүндээр үндэслэн та өгөгдсөн ажил үүрэгээ гүйцэтгэнэ. Хөдөлмөрийн гэрээ нь бичгээр байх ёстой. Та болон ажил олгогч – хоёр тал гэрээний эх хувь дээр гарын үсэг зуран хүлээн авна.

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА нь хөдөлмөр гэрээ байгуулагдах болон ажилд орсон өдрөөс эхэлдэг

Хөдөлмөрийн гэрээ юу агуулдаг:

- Таны хийх ажлын төрөл (ажлын байр).
- Ажилд орох өдөр.
- Таны ажлаа гүйцэтгэх газар.
- Хэрэв та олон ажлын байр мэдэгдэж байгаа бол, жишээлбэл, бүх аймгуудад үйл ажиллагаа явуулах ба та компанийн машин ашиглах бол жолоочийн сургалтад тогтмол хамрагдах шаардлагатай бөгөөд үүндээр үндэслэн мэргэжлийн жолоочийн ур чадварын гэрчилгээ авна. Та үүнийг өөрийн биедээ авч явах хэрэгтэй

Хөдөлмөрийн гэрээ нь ихэвчлэн дараах зүйлийг агуулна:

- **Гэрээ нь тодорхой хугацаатай Х хугацаагүй байна – гэрээ байгуулсан хугацаа.**
 - Тодорхой хугацаатай - хөдөлмөрийн гэрээнд ХЭЗЭЭС - ХЭЗЭЭ ХҮРТЭЛ хөдөлмөрийн харилцаа үргэлжлэхийг заасан байна. Та зөвхөн 3 удаа дараалан (хамгийн урт хугацаа нь 3 жил) хугацаатай гэрээ байгуулж болно. Үүний дараа та хугацаагүй гэрээтэй байх ёстой. Гэхдээ онцгой зүйлүүд байна!
 - Тодорхой хугацаагүй - хөдөлмөрийн гэрээнд хөдөлмөрийн харилцааны үргэлжлэх хугацааг заагаагүй болно.
- **Туршилтын хугацаа** – ихэвчлэн 4 сар үргэлжилнэ. Энэ бол тухайн ажил танд тохирох эсэхийг туршиж үзэх боломжтой үе юм. Энэ хугацаанд та болон таны ажил олгогч ямар ч шалтгаангүйгээр хөдөлмөрийн харилцаагаа цуцалж боломжтой. Хөдөлмөрийн харилцааг бичгээр цуцлах ёстой. Энэ хугацаанд та эхлэх цалин гэж нэрлэдэх цалин авах боломжтой бөгөөд энэ нь 4 сарын туршилтын хугацаа дууссаны дараа нэмэгдэнэ. Цалингийн хэмжээг өөрчлөх нь ихэвчлэн хөдөлмөрийн гэрээний нэмэлт бичигт тэмдэглэгдсэн байна.
- **Цалин** – хөдөлмөрийн гэрээнд нийт цалин гэж мэдэгдсэн байна. Үүнээс орлогын албан татвар, эрүүл мэндийн даатгал болон нийгмийн даатгал зэргийг хасдаг. Чех улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуулиар тогтоосон байдаг. Ажилласан хуанлийн сарын цалинг буцаан төлдөг ба ихэвчлэн сард нэг удаа.
- **Амралтын эрх** – хуанлийн жил дуусахаас өмнө өдөр эсвэл цагаар авч болно. Амралт авахыг ажил олгогчоос урьдчилан зөвшөөрсөн байх ёстой.
- **Ажлын цаг** – Чех улсад бүтэн цагаар ажиллах тохиолдолд долоо хоногт 40 цаг гэж тогтоосон байдаг. Хагас цагаар ажиллах тохиолдолд долоо хоногт ажиллах цаг багасдаг. Үүний зэрэгцээ цалин, амралт авах эрх эсвэл бусад тэтгэмжүүд багасан.

АНХААР! ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС ДУТУУ БОЛ ХҮЧИНГҮЙ!

ОЙЛГОХГҮЙ ГЭРЭЭНДЭЭ ХЭЗЭЭ Ч ГАРЫН ҮСЭГ БҮҮ ЗУР. БҮХ БАРИМТ БИЧГЭЭ ХАДГАЛНА УУ.

АНХААР! ГАДААД ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ХУГАЦАА НЬ БНЧУ-Д ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИН ХУГАЦАА НӨЛӨӨЛӨХ БОЛОМЖТОЙ!

АНХААР! ШАЛГАЛТТАЙ (СУРАЛЦАХАД ЗОРИУЛСАН) ГЭРЭЭГҮЙ АЖИЛ НЬ ХУУЛЬ БУС!

АНХААР! ТАНЫ ОРЛОГО ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ЭСВЭЛ БАЙНГА ОРШИН СУУХ ХҮСЭЛ МӨН ТАНЫ ТЭТГЭВЭРТ (АХМАДЫН ТЭТГЭВЭРТ) НӨЛӨӨЛЖ БОЛНО.